

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2018-08-30/**

Ажлын хэсгийн 47 дугаар хуралдаан 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 10.00 цагт Пума Империа зочид буудлын 2 давхарын хурлын танхимд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Энх-Амгалан, ЗГХЭГ-ийн референт Н.Балжинням, Сангийн яамны НББ-ийн газрын дарга Ч.Чимэдсүрэн, мэргэжилтэн Ж.Ивээлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын ахлах мэргэжилтэн Т.Зууннаст, Татварын ерөнхий газрын татварын байцаагч Ч.Батцэнгэл, Ашигт малтмал газрын тосны газрын орлогч дарга М.Энхжаргал, мэргэжилтэн Г.Оюунтуяа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэргэжилтэн Д.Наранцацрал, Хил хязгааргүй алхам ТББ-ийн тэргүүн Н.Баярсайхан, Байгал эхийн аврал сан ТББ-ийн тэргүүн Б.Наранцэцэг, Ил тод сан ТББ-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Хөвсгөл далайн эзэд ТББ-ийн тэргүүн Б.Баярмаа, Миний монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх О.Отгонсайхан, Хариуцлагатай уул уурхайн санаачилга ТББ-ийн ТУЗ-ын дарга Д.Сүхбаатар, МБОИЗ-ийн гишүүн Б.Батболд, Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Д.Энхболд, Оюутолгой ХХК-ийн ажилтан П.Ренчинпагма, Багануур, Эрдэнэс таван толгой ХК-ийн төлөөлж Эрдэнэс Монгол ХХК-ийн мэргэжилтэн Б.Мэндбаяр, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 19 гишүүн оролцож, ирц 57,6 хувьтай байв.

Мөн хуралдаанд Улаанбаатар аудит корпорацийн захирал Н.Осоргарав, Ахлах аудитор Б.Эрдэнэцог, ЗГХЭГ-ийн референт Б.Гандөл нар болон ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг, мэдээллийн технологийн зөвлөх Г.Ганбат, хуулийн мэргэжилтэн Б.Бадмаараг нар оролцов.

Хуралдааныг Ерөнхий сайдын ахлах зөвлөх, Ажлын хэсгийн ахлагч Б.Энх-Амгалан удирдах байсан ч Ерөнхий сайдын даалгавраар өөр ажилд явах шаардлага гарч, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмонг хурал удирдахыг үүрэг болгосоныг Ажлын хэсгийн гишүүдээс зөвшөөрөх эсхийг асууж, саналыг авсны дагуу хурлыг нээж, хурлын хэлэлцэх асуудал болон дотоод журмыг танилцуулснаар эхлэв.

Ш.Цолмон: Зөвлөхийн хэлэх үгийг товч танилцуулъя. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд урьдчилан тараасан, та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье. ОУИТБС-ын 2017 оны нэгтгэл тайлангийн ажлын эрчимжүүлэх хэрэгтэй байна, Улаанбаатар аудит корпорацийн төлөөлөл анхаарч ажиллах байх. Ерөнхий сайдын ажлын албаны зүгээс идэвхжүүлэх асуудал байвал бидний зүгээс анхаарч ажиллая. Дэлхийн банкнаас цаашид шинэ төслийн санхүүжилт гаргах боломжгүй гэсэнтэй холбогдуулан цаашид хэрхэхээ нухацтай ярилцах хэрэгтэй болж байна. Ерөнхий сайдын ажлын албанаас санхүүжилтын асуудлыг хэрхэн шийдэх талаар холбогдох яам, удирдлагуудтай зөвлөлдөх болно. ЗГХЭГ-ын дарга, сайд Занданшатартай хамт Гүржийн Тбилиси хотноо зохиогдсон “Нээлттэй Засаг түншлэл”-ийн олон улсын дээд хэмжээний уулзалтад оролцоод ирсэн. Энэ ажлын хүрээнд 2016-2018 оны Үндэсний төлөвлөгөө, ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, цаашид 2019-2020 онд хийх ажлуудын талаар өргөн танилцуулга хийгдсэн чухал арга хэмжээ болсоныг хэлмээр байна. ОУИТБС-ын тухайд ашиг хүртэгч эцсийн эзэд, ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох, олборлох үйлдвэрлэлийн төслийн түвшний тайлагнал хэрэгжүүлэх асуудлыг илүү анхаарч, эдгээр чиглэлүүдээр түлхүү ажиллахаар болж байна. 2018 онд манай улсыг ОУИТБС-ын стандартыг хангасан 2 дахь орноор хүлээн зөвшөөрсөн хэдий ч, энэ үнэлгээг хүрсэн түвшинд нь авч явахад амар хялбар биш. Иймд олон улсаас тавигдаж буй зөвлөмж, чиглэлүүдийг илүү анхаарч, алийг нь илүү анхаарч ажиллах, холбогдох хууль эрхзүйн суурь дэвсгэрийг тавьж өгөх талаар ажиллах хэрэгтэй байна. Та бүхэндээ амжилт хүсье” гэснийг товчхон танилцуулъя. Нэгдүгээр асуудал буюу Улаанбаатар аудитын танилцуулгыг сонсоё.

ХЭЛЭЛЦСЭН нь: Монголын ОУИТБС-ын 2017 оны нэгтгэл тайлангийн явц, эхлэлийн тайлан

Б.Эрдэнэцог: Сайн байцгаана уу, Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Бид эхлэлтийн тайлангийн төслийг ажлын хэсэгт хүргүүлж санал авсан. Нэгтгэл тайланд хамрагдах компанийг өмнөх жилүүдтэй адил ойролцоогоор 230 компанийг хамруулахаар болсон. Материаллаг байдлыг тооцохдоо улсын татвар, орон нутгийн татварыг тооцсон. Бид төсөвт 300 сая төгрөгнөөс дээш татвар төлсөн, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудыг заавал оруулахаар сонгосон. Түүвэрлэн хамруулах аргаар 8 компанийг сонгосон. Засгийн газрын тайланд 100 сая төгрөгнөөс дээш төлбөр орлого бүхий компаниудыг хянаж 23 компани нь уул уурхайн бус үйл ажиллагаа явуулдаг болохыг тогтоосон. Ажлын албанаас 8 компанийг санал болгосныг оруулсан. Материаллаг босгыг тогтоохдоо Засгийн газрын тайланг үндэслэсэн. Эдгээр компаниуд нь нийт төлбөр орлогын 98,47 хувийг эзэлж байна. Төлбөр орлогын материаллаг байдлын талаар Эхлэлтийн семинар дээр дэлгэрэнгүй танилцуулсан билээ. Өгөгдөл мэдээллийн чанар бүлэг 4.1 болон 4.2 дугаар бүлэгт тусгасан. Үүнд ОУИТБС-ын тайлагнах үйл явцад оролцож буй компаниуд, төрийн байгууллага аудитын баталгаажуулалт, үйл явцын судалгаа болон хараат бус хянагч нэгтгэгчид ямар мэдээлэл гаргаж өгөх талаар оруулсан. Нэмэлт мэдээллийн маягтад зарим өөрчлөлтийг оруулахаар болсон. Үүнд: бенефициар өмчлөгийн мэдүүлэг, ашигласан усны мэдээлэл, хог хаягдлын мэдээлэл, ажилчдын мэдээлэл, төрийн өмчит байгууллагуудаас авах мэдээлэл зэрэг маягтуудын өөрчлөлтийг оруулсан. Төрийн байгууллагын мэдээллийг нэмэлтээр албан бичгээр авна. ТӨК-ууд болон газрын тосны компаниудаас мөн нэмэлт мэдээллийг шинэчилсэн маягтын дагуу авна. Мэдээллийг системтэйгээр ил тод болгох талаар 2017 оны тайланд баримтлах гол хандлага бол цахимаар ил болсон мэдээллийг дахин оруулахгүй, хэрэгцээтэй гэж үзсэн зарим мэдээллийг тайланд тоймлон хураангуй зураг хэлбэрээр оруулах нь зохимжтой гэж үзэж байгаа. Бид 7 сарын 6-нд эхлэлийн хэлэлцүүлэг хийж 8 сарын 20-нд эхлэлийн тайлангийн төслийг хүргүүлээд өнөөдөр эхлэлийн тайланг батлуулахаар танилцуулж байна. 9 сарын 30-нд нэгтгэлийн явц, 11 сарын 15-нд нэгтгэлийн тайлангийн төслийг Ажлын албанд танилцуулж, 11 сарын 30 нд эцсийн тайланг танилцуулах төлөвлөгөөтэй байна. /Танилцуулгыг хавсаргав/

Ш.Цолмон: За баярлалаа, танилцуулгатай холбогдуулан асуулт санал хэлэх гишүүд байна уу?

О.Отгонсайхан: Та бүхэнд баярлалаа, урьд тавьсан саналуудыг оруулсан байна. Хавсралт дахь хүснэгтүүдийн гарчигны багана дахь тайлбар, нэршилүүдийг тодорхой болгочихвол зүгээр байна. Өөр санал байхгүй.

Б.Эрдэнэцог: Бид эхлээд сонгосон байсан 230 компанийн жагсаалтыг тараасан байсан. Дараа нь ажлын албанаас санал болгосон 8 компанийг нэмж оруулсан тул жагсаалтыг шинэчлэн дахин тараасан байгаа.

Н.Баярсайхан: Улаанбаатар аудитынханд баярлалаа. Компаниудыг сонгосон шалгуур, арга зүйг боломжийн байна гэж харж байна. Хэдэн хэдэн асуулт байна. Нэгдүгээрт, нэмэлт мэдээллийн маягтын өөрчлөлт одоо гарч байгаа юу? хоёрдугаарт, нэгтгэл тайланд хамрагдах 230 компанийн жагсаалтад 40 гаруй компани тайлагнаагүй гэсэн байна. Эдгээр компаниуд тайлангаа гаргаагүй байгаа гэсэн үгүү? Танилцуулгад 8 сарын 14-нд ажлын албанаас мэдээлэл авсан гэж байна, тэгэхээр одоо л мэдээллээ цуглуулах гэж байгаа гэж ойлгож болох уу? Бид нэг сарын дотор тохируулгаа хийж амжих уу, заавал 10 сарын 30 гэж тодорхой шахах хэрэгтэй юу? Түүнчлэн ТАН эвсэл жил бүр өгдөг саналууд байдаг, ажлын даалгаварт ороогүй учраас авах боломжгүй гэсэн тайлбарыг сонсох байсан. Иймд олон удаагийн туршлага, мэдээлэл дээр үндэслэн нэлээдгүй урт жагсаалт бүхий санал өгсөн, энэ саналууд энэ жилийн тайланд хэд нь тусгагдахаар байна вэ? Баярлалаа.

Б.Эрдэнэцог: Бид эдгээр 12 маягтыг бий болгоод 2, 3 жил болж байна. Хэрэгжүүлэх явцад гишүүдийн саналыг үндэслэн өөрчлөх, сайжруулах байдлаар ажилладаг. Энэ жилийн хувьд нэмэлт мэдээллийн маягтууд дээр шинээр өөрчлөлт оруулсан. Өөрчилсөн болон шинээр хийсэн маягтуудаа өнөөдөр танилцуулж байна. Өмнө ажлын хэсгийн гишүүдэд явуулсан байгаа. Жишээлбэл: Ашигласан усны мэдээлэл, хог хаягдлын мэдээлэл шинээр оруулсан, ажилчдын мэдээлэл, бенефициар өмчлөгчийн мэдүүлэг гэсэн маягтуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Жагсаалтад байгаа зарим компаниуд анхны тайлангаа цахимаар тушаагаагүй байгаа тул тоо байхгүй. Бид эдгээр 230 компанийг сонгож авахдаа Засгийн газрын тайланг үндэслэл болгодог. Ер нь компаниуд 4,5 сардаа тайлангаа гаргасан байсан харин 3 аймаг тайлангаа гаргаагүй байсныг нэмж оруулж компанийн сонголтоо эцсийн байдлаар гаргасан. ТАН эвслээс авсан саналыг бид анхааралтай авч үзэн эхлэлтийн тайланд тусгасан. Уг санал нь нилээд дэлгэрэнгүй, авч болохуйц саналууд байсан. Бид боломжтойг нь тайландаа оруулна, бүр боломжгүйг нь тайлбар өгнө.

Н.Баярсайхан: Эдгээр 40 гаруй компани тайлангаа өгөөгүй байна гэдэг чинь нэгдүгээр улиралд тайлагнах үүргээ хэрэгжүүлээгүй байгаа гэсэн үг байна. Тиймээс хурлын шийдвэрт энэ талаар оруулах хэрэгтэй байна. Томоохон компаниуд тайлангаа гаргаагүй байна гэдэг чинь 1800 гаруй компаниас жижиг компаниуд ямар байх вэ, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байна гэж үзэж байна.

Б.Баярмаа: Ашигласан усны мэдээлэл шинээр орж байгаа юм байна. Усны төлбөр нь ОУИТБС-ын маягтад угаас байдаг тул мэдээлэгдээд явах байх. Харин хог хаягдлын мэдээлэлд төлбөр нь байхгүй харагдаж байна. Орон нутагт ашигласан усны төлбөрийг өөрсдөө тоогоо хэлээд л төлчихдөг юм байна. Хог хаягдлын төлбөрийг оруулмаар байна. Одоо бас бохир ус зайлуулсны төлбөр гэж байгаа. тэдгээрийг оруулчихвал зүгээр байна.

Б.Эрдэнэцог: Болно оо.

Б.Батболд: ТӨК-уудын асуудлуудыг дэлгэрэнгүй оруулахаар болсон байна. Үүнийг албан бичгээр авна гэсэн байна. ТӨК-ууд энэ заагдсан мэдээллүүдийг албан бичгээр өгөх болов уу, үүнийг цахим тайлангаар авч болохгүй юу?

Б.Эрдэнэцог: Хэрвээ цахим тайлангийн системд маягтаа оруулчихвал бүх сонгогдсон компаниуд бөглөх болно. Бид төрийн өмчийн 19 компанид маягтаа өгөөд албан бичгээр мэдээллээ авах бодолтой байгаа. Ер нь цахим тайлангийн системд оруулж болно гэхдээ зөвхөн ТӨК-д хамаарна гэдгийг сайн зааж өгөх хэрэгтэй. Энэ мэдээлэлд ТУЗ-ын хараат биш гишүүн хэн бэ, түүнийг сонгох сонгон шалгаруулалт яаж явагдсан зэрэг мэдээлэл багтах бөгөөд цахим тайлангаар шууд бөглөж болохгүй мэдээллүүд байгаа.

Б.Батболд: Хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нь ТӨБЗГ материалаа аваад хийдэг боловч сонгон шалгаруулах явц нь асуудалтай байдаг гэж үздэг. Засаглалын сургалтад 20 гаруй ТББ-ын хүмүүсийг суулгаж материалыг авчихаад сонгон шалгаруулалтад нэг ч хүн сонгогдоогүй байсан тохиолдол гарсан. Сонгогдоогүй нөхцөл нь юу вэ гэхэд түүнийг тайлбарлах ёсгүй гэдэг. Иймд үүнийг ТӨК-уудад ил тод болгоё гэсэн саналтай байна. Энэ талаарх мэдээлэл албан бичиг дээр яаж тусгах, хариу яаж ирэх болон тайланд хэрхэн тусгах вэ гэдэг нь сонирхолтой байна.

Б.Эрдэнэцог: Энэ нь 11-хэн компани байгаа болохоор асуудал гайгүй байх гэж бодож байна. Мөн албан бичгээр хандаад эргээд албан бичгээр хариугаа авна гэдэг нь тайлангийн үнэн зөв байдал, мэдээллийн баталгаажуулалтад нөлөөтэй юм.

Б.Баярмаа: Ажилчдын мэдээллийн талаар гаднаас авах ажиллах хүч нь квотоосоо давчихвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээний нөхөн төлбөр өгдөг гэсэн хууль байгаа. Энэ хуулийн дагуу тухайн компаниас хэдий хэмжээний төлбөр төлсөн байна вэ? Мөн манайд байхгүй мэргэжлийн ажилтаны

жагсаалтыг Хөдөлмөрийн яамнаас гаргаад дээрх төлбөрөөс чөлөөлдөг. Энэ талаарх мэдээлэл тайлангийн маягтад байна уу? үүнийг бид мэдээлэх ёстой.

Ш.Цолмон: Үндсэн мэдээлэлд квотоос давсан ажилтны төлбөрийн талаарх мэдээлэл байгаа. Харин чөлөөлсөн талаарх нь байхгүй.

Б.Баярмаа: Энэ мэдээллийг оруулмаар байна. Ялангуяа Эрдэнэцагаан дээр энэ асуудлыг их гаргаж ирдэг.

Б.Эрдэнэцог: Энэ талаар Хөдөлмөрийн яамны мэдээлэлд ордог. Тайланд оруулж болно.

Б.Баярмаа: Компаниуд уурхай хаах үеийн зардлыг урьдчилан төвлөрүүлэх талаар Сангийн яамны мэргэжилтэн зааж байсан. Энэ мэдээллийг оруулах боломжтой болов уу? Бидний хувьд энэ асуудал маш чухал байгаа. Уурхай ажиллаж байх үедээ мөнгөтэй байж байгаад яг хаах үедээ мөнгөгүй болчихдог. Үүнийг бид шаардаад тайландаа оруулаад байвал уурхай хаах үедээ уурхайгаа хаяад явахгүй өөрсдөө нөхөн сэргээлтээ хийх боломжтой болох юм.

Б.Эрдэнэцог: Баталгаажуулалтын хэсэг буюу өгөгдөл мэдээллийн чанар гэдэгт удирдлагын хариуцлагын захидал, аудитын тайлан зэргийг авдаг. Аудитын дүгнэлтийг үнэлж үзэж байгаа. Хэрвээ тухайн байгууллага НББОУС-ын дагуу санхүүгийн тайлангаа гаргаад түүнд аудит зөрчилгүй дүгнэлт өгсөн бол тухайн ашиглалтын компани нөхөн сэргээлтийн нөөц байгуулсан байна гэж үзэж болно. Аудитор нэгэнт тийм дүгнэлт өгчихөөд байхад бид дахин энэ талаар асуугаад байх зохимжгүй. Хэрвээ нөөц байгуулаагүй бол аудитор байгуулах ёстой гэсэн хязгаарлалттай дүгнэлт өгөх ёстой. Тэр утгаараа стандартын дагуу хийгдэж байгаа гэж үзэн баталгаажуулалтын дагуу явъя гэж бодож байгаа. Өмнө нь бид стандартын гол гол асуудлуудыг хэрэгжүүлж байна уу үгүй юу гэдэг мэдээлэл авах зорилгоор цаасаар судалгааны маягт авдаг байсан. Энэ нөөцийн талаарх мэдээллийг авдаг байсан, маш хангалтгүй мэдээлэл гардаг байсан.

Б.Осоргарав: Өмнө орчихсон мэдээллийг дахин оруулах хэрэг байна уу? хэлэлцээд оруулах санал гарвал оруулж болно.

Б.Баярмаа: Энэ хөрөнгө тайланд тусгагдаад явах нь чухал байна. Энэ талаарх мэдээллийг нэмэлт маягтаар аваад мэдээлэх нь хэр хүндрэлтэй вэ? Энэ хөрөнгө байгаа эсэх нь ИНБ-уудад маш чухал байна.

Г.Оюунтуяа: Энэ чинь Байгаль орчны яаманд байршуулсан барьцаа хөрөнгө биш юмуу?

Б.Баярмаа: Биш, уурхай хаах үеийн нөхөн сэргээлт хийх зардлын нөөц байгуулах асуудал.

Ч.Чимэдсүрэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би өнөөдөр анхныхаа хуралд сууж байна. Энэ асуудал дээр манай мэргэжилтэн маань хариулж, би нэмэлтээр хариу өгье.

Ж.Ивээлэн: Одоогийн байдлаар зарим компаниуд нөөцийг байгуулаад явж байгаа. Ашигт малтмалын тухай хуульд үйл ажиллагаа дуусахаас тэдэн жилийн өмнөөс эхлэн нөөцийг байгуулна гэсэн заалт байдаг. Ашиглалт эхлэнгүүт байгуулах ёсгүй. Энэ нь байгууллага бүр дээр янз бүр байгаа, бүх байгууллагад жигд байгуулна гэдгийг хэлж мэдэхгүй байна. Стандартаараа уурхай хаахаас 2-3 жилийн өмнөөс уурхай хаах үеийн зардлын нөөцийг байгуулна гэсэн байдаг.

Ч.Чимидсүрэн: Та бүхний энэхүү санал гаргаж байгаа тайланд чухал хэрэгтэй мэдээлэл байна гэвч практик дээр энэхүү нөөцийг хэрхэн байгуулах, хаана байршуулах болон яаж зарцуулах талаарх асуудал нилээд орхигддог. Манай яаманд энэ талаар саналаа хүргүүлэх нь зүйтэй. Нэгтгэл тайлан хийж байгаа Улаанбаатар компанийг хийгээд шахаад байхаар цаанаа энэ нь эрхзүйн боломж байна уу үгүй асуудал гарна. Иймээс энэ асуудлыг хөндөх нь зүйтэй цаашлаад манай албанаас бүртгэл тооцоонд хэрхэн тусгах талаар дүгнэлт гарсны дараа шийдэх ёстой асуудал байх гэж бодож байна.

Н.Баярсайхан: Бенефициар өмчлөгчийн талаарх мэдээлэл хэр ирж байна, өгөх шинжтэй байна уу, компанийн тайлангаа задалж үзсэн үү? Байгаль орчны яам нөхөн сэргээх барьцаа хөрөнгийн мэдээллээ өгсөн үү, маш хойрго байдаг.

Б.Эрдэнэцог: Үзээгүй байгаа. Бенефициар өмчлөгийн талаарх мэдээллийг Ажлын хэсгээр нэмэлт мэдээллийн маягтыг баталсны дараа компаниуд бөглөх ёстой. Хэрвээ мэдээллийн маягтыг баталчихвал бид компаниудад маягтыг хүргүүлнэ мөн маягтаа хэрхэн бөглөх талаар компаниудад сургалт явуулдаг. Түүний дараа компаниудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгээд тайландаа оруулдаг байгаа.

Ш.Цолмон: Энэ жил Байгаль орчны яам тайлангаа өгсөн, компани тус бүрээр гаргасан.

Ч.Батцэнгэл: Өмнөх жилүүдийн тайлан татвар хураамжийн зөрүүг тулгалтын дараа тааруулдаг, зөрүү багасдаг байсан. Энэ жилийн тайлангийн хувьд нэмэлт мэдээллийг нилээд авч өөрөөр хэлбэл эдийн засагт үзүүлж байгаа үр нөлөөг тодорхойлох зорилготой, өвөрмөц тайлан болох нь гэж харж байна. Гаднын байгууллагууд ч үүнийг хүсээд байдаг. Та бүхэнд амжилт хүсье, дэмжиж ажиллахаа илэрхийлье.

Ш.Цолмон: Эхний асуудалтай холбоотой санал байна уу?

Б.Батболд: Бид өнөөдөр нэмэлт мэдээллийн маягтыг батлах юм байна. Үүнийг харахад зарим асуулт нь зохимжгүй харагдаж байна. Жишээлбэл, тухайн бенефициар эзэмшигчийн оршин суугаа хаяг гэж байна. Дорж хаана амьдардагийг иргэний бүртгэлийн мэдээллээс олох боломжтой. Магадгүй ямар нэгэн жижиг асуудлаас болоод орон гэрийнх нь цонхыг хагалах зэрэг нөхцөл байдал гараад байдаг. Иймэрхүү юмнаас үүдээд оршин суугаа гэрийн хаягийг ил болгох нь зохимжгүй байна, хасчихмаар байна.

Б.Эрдэнэцог: Шаардлагад байхаар заасан байдаг.

Г.Оюунтуяа: Ер нь бид стандартыг үг өгүүлбэр бүрийг дагах ёс байхгүй. Өөрийн улс орны онцлог, тухайн орчиндоо тохируулах хэрэгжүүлэх боломжтой биз дээ?

Ш.Цолмон: Тийм.

Д.Наранцацрал: Аж ахуйн нэгжүүд Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-ийн дагуу тайлагнаж байгаа. Хуулинд “Бүтээгдхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвараа мэдээлнэ” гэж заасан байдаг. Бид аж ахуйн нэгжид арга хэмжээ авахаар болоод прокурор дээр очихоор энэ чинь зөвхөн мэдээлнэ гэж байна гэдэг. Торгуулийн арга хэмжээ авах үндэслэлгүй болоод байна. Тухайн аж ахуйн нэгж өөрийн цахим хуудас дээрээ мэдээллээ тавьчихсан байхад болохоор харагдаад байгаа. Заавал ажлын албанд мэдээлэх шаардлагагүй мэтээр хуулинд заасан байдаг. Тэгэхээр аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлт болон бусад нэмэлт мэдээллүүдийг гаргах хуулийн үндэслэлгүй гэж надад харагдаад байна. Хуульд заасан хэмжээний мэдээллээ авахгүй хэтэрхий их нэмэлт мэдээллийг аж ахуйн нэгжүүдээс шаардаж байна. Тэгэхээр энэ маань хуулийн заалтад хэр нийцэж байна гэдгийг эргэж харах хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: МХЕГ-ын мэргэжилтэн өөрийн ажлын байр сууринаас ярьж байна. Хаалттай байгаа бүх асуудлыг ил тод болгох нь энэхүү санаачилгын зорилго юм. Шийдвэрийн төслийн 1, 2-ийг хэвээр үлдээгээд 3 дугаарт 48.10-ийн дагуу тайлан гаргаагүй компаниудыг жагсаалтыг гаргаж, нийтэд мэдээлэх гэсэн шийдвэрийг Ажлын албанд даатгах саналтай байна. Тайлан гаргаагүй компаниудын хар жагсаалт гаргавал бизнесийн нэр хүндэд халдах замаар, тэднийг хариуцлагажуулахад чухал хувь нэмэртэй гэж бодож байна, МХЕГ ажлаа хийвэл хийг, байвал байг.

Г.Оюунтуяа: МХЕГ-ийн хувьд арга хэмжээ авах гэхээр зөвхөн энэ заалтаар болохгүй байна гэдгийг л хэлээд байна.

Д.Наранцацрал: тийм, Зөрчлийн тухай хуульд дээрх асуудлууд бүгд хамрагдсан учраас бид 10 сая төгрөгөөр торгох арга хэмжээгээ авч байгаа. Манайд зөвхөн хайгуулын тайлан төлөвлөгөө батлуулж байгаа. Үүнийг батлах явцдаа Ил тодын тайлан гаргасан байна уу гэдгийг давхар хянаж байгаа. Хэрвээ тайлангаа өгөөгүй байвал тайлангаа өгөх эсвэл торгуулийн арга хэмжээ авч байна. Ашиглалт дээр ямар ч хяналт тавих боломжгүй байгаа. 10 сая төгрөгийн торгууль нь хайгуулын аж ахуйн нэгжүүдэд маш хүндээр тусч байгаа. Бид хуулийн дагуу арга хэмжээгээ аваад явж байгаа ч аль аль талдаа хүндрэлтэй байгаа талаар мэдээлж байна.

Ш.Цолмон: Амьдрал дээр ийм асуудал их байгаа, манайх руу өдөр бүр шахуу утасддаг.

Д.Сүхбаатар: Ашиг хүртэгч эздийг гэмт хэрэгтэн барьж байгаа юм шиг хараад өөрсдөө тийм сэтгэл хөдлөлд автмааргүй байна. Тухайлбал, банкны хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг аваад олон нийтэд ил болгохгүй нэр хүндэд халдахгүй маягаар ажилладаг. Саяхан Сэлэнгэ аймгийн ИТХ-ын дарга өөрийн хүүгийн талаарх мэдээллээ ил болголоо. Цаашид энэ хүнийг яах бол гэсэн бодол байна. Аливаа мэдээллийг шоу болгохгүй байдлаар хандмаар байсан гэсэн саналтай байна.

Ш.Цолмон: За тэгвэл олонхийн саналаар гэрийн хаягийг нь хасах уу?

Гишүүд: Тэгье ээ.

М.Энхжаргал: Оршин суугаа хаяг, иргэний бүртгэлийн хаягаар гэсэн байна. Энэ хоёрыг хоёуланг нь хасъя, олохоо хүрвэл олно. Хэрвээ шаардлагатай юм бол оффисын хаягаар ч олж болно.

Нэгдүгээр асуудлаар гаргасан шийдвэр:

1. Эхлэлийн тайланг батлах, холбогдох төлбөрийг хийхийг Ажлын албанд зөвшөөрөв;
2. Нэгтгэлийн явцын тайланг 9 дүгээр сарын 30, нэгтгэл тайлангийн төслийг 11 дүгээр сарын 15-ны дотор тус тус Ажлын хэсэгт танилцуулах;
3. Ашигт малтмалын тухай хуулийн 48,10 заалтын биелэлтийг гаргаж, тайлан гаргаагүй компаниудын нэрсийг нийтэд ил тод болгох;

ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын төслийн түвшний тайлагналын тухай танилцуулга

Ш.Цолмон: ОУИТБС-ын мэдээллийг нэгтгэсэн биш, компани Засгийн газрын байгууллага, орлогын урсгалын төрлөөр задлан хэвлэн нийтлүүлэх, олборлох үйлдвэрлэлийн төслийн түвшний тайлагналыг 2018 оны 12 дугаар сарын 31-гаас 2020 оны 12 дугаар сарын 31-ны хооронд 2 жилийн хугацааг хамруулах хэрэгжүүлэхийг шаардсан байна. Төслийн түвшний гэдгийг АНУ-ын Үнэт цаас, биржийн комиссоос батласан журам, Европын холбооны холбогдох шаардлагуудад зааснаар ойлгохоор болсон. Европын холбооны НББ-ийн удирдамжийн 41.1-д зааснаар "Төсөл гэдгийг нэг гэрээ, тусгай

зөвшөөрөл, түрээс, концесс, тэдгээртэй адил хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичгээр удирдлага болгон хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны цогц гэж ойлгохоор тодорхойлж өгсөн байна. Энэ нь стандартын шаардлага хэдий ч бүх орон хэрэгжүүлэхгүй байна. Одоогоор бүрэн хэрэгжүүлж байгаа 3 улс, хэсэгчлэн хэрэгжүүлж байгаа нилээд орнуудын тоонд Монгол улс орж байна. Олборлох үйлдвэрлэлийн төслийн нэрээр мөнгө угаах, хөрөнгө шамшигдуулахаас урьдчилан сэргийлэх, тухайн төслийг олон нийтэд танилцуулах, хүртээл болгох, үр шимийг нийтэд ил болгох, нэг ойлголттой болцгоох, итгэлцлийг бий болгох зорилготой. Төслийн тухай хууль эрх зүйн тодорхойлолт байдаг бол тухай хуулийн холбогдох заалтыг удирдлага болгох, байхгүй тохиолдолд боловсруулж, хэлэлцсэний үндсэн дээр Ажлын хэсгээрээ батлуулж, мөрдлөг болгоно. Төслийн түвшний тайланг цаг, цаас хэмнэх, шуурхай байдлыг хангах үүднээс аль болох цахимаар, нэг улс, нэг төслийг хамрах байдлаар байна. Төслийг хэрэгжүүлэхэд холбогдсон олсон орлого, гарсан бүх зардлыг хамруулна. Жилдээ нэг удаа тайлагнана. Монгол улсад ОУ-ын стандартын шаардлагын дагуу 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, тайлангийн маягтыг Ажлын хэсэг болон ОУ-ын НБДНГ-т танилцуулах, Үндэсний зөвлөлд танилцуулах, 2017 оны нэгтгэл тайланд орж байгаа компаниудаар нэмэлт мэдээллийг маягтаар гаргуулах, туршилтын арга хэмжээг Улаанбаатар аудит корпорацитай хамтран хэрэгжүүлэх зэрэг саналуудыг гаргаж байна. Ерөнхийдөө Улаанбаатар аудиттай ярьчихсан байгаа. Мөн ОУ-ын НБДНГ-аас Улаанбаатар аудиттай утсаар ярьж энэ асуудлаар зөвлөлдөх саналтай байгаа. Энэ талаар та бүхэн саналаа өгнө үү. Улаанбаатар аудит энэ жил хийх боломжтой бол сайн байна, боломжгүй бол 2019-2020 оны тайланд оруулах дүр зураг байгаа. Хуучин мэдээлэл дээрээ үндэслэн нэмэлтээр оруулах ажил байгаа.

Б.Батболд: Компаниудаас санал авсан юм уу? Бид шууд батлачихаар компаниуд зөвшөөрөхгүй байж болно.

Ш.Цолмон: Одоогоор санал аваагүй, боловсруулаад санал авах боломжтой. Олон улсын жишээн дээр Оюутолгой компани орсон байна лээ. Мэдээллээ нилээд тодорхой гаргадаг гэсэн байна. Тэгэхээр боломжтой байх гэж үзэж байгаа. Одоо тайланд бөөн дүнгээрээ явдаг үүнээс уул уурхай, олборлолтын орлого зарлагыг салгаж харуулах, тухайн төсөл хэр зэрэг ашигтай байгаа зэрэг болон үр шимийг нийтэд нээлттэй мэдээлэх боломжтой болно гэдэг үүднээс төсөл бүрээр тайлагнах санал байгаа.

Г.Оюунтуяа: Энэ нь олон салбарт үйл ажиллаж байгаа компаниуд л салгаж тайлагнана гэсэн үг биз дээ. Оюутолгой шиг нэг төсөлтэй бол шаардлагагүй юм байна.

Б.Эрдэнэцог: Тийм, Монголросцветмет гэх мэт олон лицензтэй, өөр өөр аймаг суманд олборлолт явуулдаг компаниуд гаргах юм. Бид 2017 оны тайланд тодорхой асуудлуудыг оруулахаар болсон. Жишээлбэл, Төсөл гэж юуг хэлэх, ямар төлбөр орлогыг оруулах, хэн тайлагнахыг тодорхой болгох, цахим тайланд өөрчлөлтийг оруулах гэсэн ажлуудыг хийхээр ярьж байна. Одоо шууд 2017 оны тайлангийн мэдээллийг төсөл бүрээр тайлагнуулах гэхээр хүндрэлтэй байгаа. Иймээс төсөл гэж юуг хэлэх вэ гэдэг тодорхойлолтоо тодорхой болгоод, маягтаа батлуулаад, 2018 ондоо багтааж цахим тайлангийн системд оруулаад 2019 оны тайланг авахад бэлэн болсон байвал зохистой юм болов уу. Үндсэн мэдээлэл дээрээ танайх хэд хэдэн төсөл хэрэгжүүлдэг үү гэсэн асуулга тавиад хэрвээ тийм гэвэл төлбөр орлогын урсгалууд нь төслөөр задрах боломжтой болж, мэдээлэл оруулдаг байхаар тайландаа өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Ш.Цолмон: Баярлалаа, шийдвэрийн төсөлд оруулах өөрчлөлт байна уу?

Б.Батболд: Шийдвэрийн төсөлд "...холбогдох маягтыг эцэслэн боловсруулж, батлуулна" гэсэн байна. Бидний хувьд төслийн түвшний тайлагнал гэдгийг нэг ойлголттой болгож байж цааш явмаар байна.

Ш.Цолмон: За тэгвэл, холбогдох маягтыг боловсруулан компаниудаас санал авах гэдэг байдлаар шийдвэрийн төсөлд оруулъя.

Хоёрдугаар асуудлаар гарсан шийдвэр:

“Холбогдох тодорхойлолт, маягтыг дахин боловсруулж, компаниудын төлөөлөлд танилцуулж, тэдний саналыг авахыг Ажлын албанд даалгав.”

ХЭЛЭЛЦСЭН нь: ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох нь:

Т.Зууннаст: 2018 оны 5 дугаар сарын 1-ны өдийн Ажлын хэсгийн хуралдаанаар ОУИТБС-ын мэдээллийг системтэйгээр ил тод болгох ажлын хэсгийг байгуулах шийдвэр гарсан. Одоо хэрэгжиж буй явц нь тухайн жилийн 1-2 дугаар улиралд хараат бус нэгтгэгчийг сонгон шалгаруулж байгаа. Үүний дараа тайлангийн эхлэлтийн үе шат, мэдээлэл цуглуулах ажлын 3-4 дүгээр улиралд хийдэг. Нэгтгэл тайланг тухайн оны 4 дугаар улиралд гаргаж, батлуулдаг байна. ОУИТБС-ын стандартаар ил тод болгох мэдээллүүд байдаг. Үүнд, олборлох салбарын эрх зүйн зохицуулалт, төсвийн бодлогын талаарх тодорхой мэдээлэл, салбарын талаарх товч мэдээлэл, хайгуулын томоохон үйл ажиллагааны талаарх мэдээлэл, олборлох салбар дахь төрийн оролцооны талаарх мэдээлэл, олсон орлогын хуваарилалт, менежмент, зарцуулалт, лиценз олгох явц, бүртгэл, олголтын талаарх мэдээлэл, эцсийн эзэмшигчийн талаарх мэдээлэл, гэрээ зэрэг мэдээллүүдийг ил тод болгохыг шаардсан байдаг. 2018 оны 3 дугаар сард ОУИТБС-ын ОУ-ын НБДНГ-аас Монгол улсад ОУИТБС-ын мэдээллийг ил тод болгоход бэлэн байгаа эсэхийг судалсан байна. Судалгаагаар мэдээллийн 70 орчим хувь нь ил болсон, 30-аад хувь нь ил тод болгох шаардлагатай байна гэсэн. Үүнтэй холбоотой тодорхой зөвлөмжүүдийг өгсөн. Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор, Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулах эсвэл Үндэсний зөвлөлийн шийдвэр гаргуулах саналтай байна. Түүнчлэн 2018 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулна гэж тусгасан байгаа. манай яамнаас “Уул уурхайн хууль”-ийн төсөлд ил тод байдлын талаарх асуудлыг нэг бүлэг болгон оруулсан байсан. Энэхүү хуулийн төсөл маань цааш явахгүй байдалтай байгаа учраас яамны зүгээс боловсруулсан “Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хууль” ийн төслөө явуулах саналтай байгаа. Энэ хуулийн төсөлдөө ил тод болгох мэдээллийн талаар оруулах болон хуулийн ажлын хэсгийг хуучин бүрэлдхүүнээр ажиллуулвал ямар гэсэн асуудлуудаар санал авъя. Энэ хуулийн төсөл нь өмнөх Засгийн газрын үед боловсруулж, өргөн бариад, Эдийн засгийн байнгын хороон дээр очсон байдаг. Өмнөх Улсын их хурлын хугацаа дуусаад, гацсан байгаа. Ерөнхийдөө өргөн барихад бэлэн төсөл байгаа. Одоогийн нөхцөл байдлаа тусгаад, нэмж оруулах зүйл байвал нэмээд, сайжруулаад явах боломжтой. Ингээд ОУИТБС-ын мэдээллийг ил тод болгох ажлын хүрээнд Засгийн газрын тогтоол боловсруулах эсэх дээр та бүхнийг саналаа өгөхийг хүсч байна.

Г.Ганбат: Ил тод болгох мэдээлэлд гэрээний мэдээлэл байгаа. Гэрээний мэдээллийг нэгтгэн бааз байгуулсан. Мөн бенефициар өмчлөгчийн мэдээлэл, Ашигт малтмалын газрын лицензийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл бүрэн биш байгаа, кадастрын мэдээллийг шинэчлэх шаардлагатай байгаа. Мөн лиценз олгохтой холбоотой сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг бичгээр авдаг байсан. Үүнийг ил тод болгох шаардлагатай байгаа. Түүнчлэн төрийн өмчит компаниудтай холбоотой мэдээлэл, Хөдөлмөрийн яамтай холбоотой ажиллах хүчний тухай буюу уул уурхайн салбараас эдийн засагт оруулж байгаа үр ашгийн талаарх мэдээлэл, Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн санд хуваарилж байгаа мөнгийг ямар томъёогоор яаж хуваарилж байгаа талаарх мэдээлэл зэрэг нийт мэдээллийг ил тод болгох, тухайн байгууллагуудын цахим хуудас дээр мэдээлдэг болгох шаардлагатай байна. Одоогоор ганцхан Норвеги улс 100 хувь шилжсэн байгаа. Нэгтгэл тайланд хэтэрхий олон тооны бага дүнтэй төлбөр төлсөн компанийг хамруулж байна гэсэн. Нийт орлогын 80 гаруй хувийг 20-иод компани бүрдүүлчихээд байхад 200 компанийг сонгох шаардлага байна уу гэсэн зөвлөмжийг ОУ-ын НБДНГ-аас өгсөн байгаа. Мөн тайлан авч байгаа хугацаагаа эргэж харах, цахим

тайлангийн системд тайлан хүлээн авдаг хэсгийг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд шилжүүлж өгөх талаар зөвлөмж ирүүлсэн байна. Хэрвээ дээрх шаардлагуудыг бүрэн хангачихвал Монгол улсаас ОУ-ын НБДНГ-т хүсэлт гаргаад, цаашдаа хараат бус нэгтгэгч шаардлагагүй жил бүр тайлан гаргах шаардлагагүй болох юм байна. Ерөнхийдөө 1-2 жилийн дотор хараат бус нэгтгэгч авах шаардлагагүй болно гэж үзсэн байна. Ер нь цаасан тайлан хэвлэгдэхгүй болно гэсэн үг.

Д.Сүхбаатар: Мэдээллийг системтэйгээр ил тод болгох гэдэг дээр талуудын үүрэг оролцоог авч үзэж байна уу? Өөрөөр хэлбэл яамдуудын үүрэг оролцоог хэрхэн хангах талаар яаж ажиллаж байна? Жишээлбэл, Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмалын газар ямар үүрэг хүлээх вэ?

Т.Зууннаст: Бид мэдээллийг ил тод болгох зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газрын тогтоол гаргах уу хуулиндаа оруулах уу гэдгийг хэлэлцэж ярилцсан. Засгийн газрын тогтоол гарсан тохиолдолд оролцогч талуудыг үүрэгжүүлээд өгнө. Компаниудыг аль болох зөрүү багатай мэдээллийг ил тод болгохыг үүрэг болгож байгаа.

Г.Ганбат: Одоо Засгийн газар мэдээллээ тайлагнах асуудлыг Засгийн газрын 222, 263-р тогтоолоор баталгаажуулж өгсөн. Уг тогтоолд төрийн ямар ямар байгууллагууд стандартад шаардсан мэдээллийг гаргаж өгөх вэ гэдгийг заасан байдаг. Компаниудыг Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-ын дагуу тайлан гаргахыг шаардсан байдаг. Хэрвээ хуулинд оруулж өгвөл бүр сайн болно.

Ш.Цолмон: Тухайн яам мэдээллийг гаргахад юу нь болохгүй байгаа талаар судалгаа хийсэн үү?

Г.Ганбат: Үзсэн, зарим нь мэдээлэл гаргах программ хангамж байхгүй гэсэн байна. Кадастрын мэдээллийн системийг сайжруулах шаардлагатай гэсэн байна. Талууд ярилцаад тайлан хүлээн авах систем нь Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаман дээр байх уу эсвэл Ашигт малтмалын газар байх уу гэдгийг шийдэх байх.

Б.Батболд: Яаманд шилжүүлэхээр бүр замхараад алга болох биш үү?

Г.Ганбат: Цаашид тогтвортой байдлыг хангах үүднээс цахим тайланг төрийн байгууллагад шилжүүлж байгаа. Хэрвээ ажлын албаны санхүүжилт зогсвол цахим тайланг хэн авч явах вэ гэдэг асуудал гарна.

Б.Дэлгэрмаа: Өмнө нь ОУ-ын НБДНГ-ын Алекс Горди ирээд нөхцөл байдлын судалгаа хийсэн, зарим яамны төлөөлөл уулзаж, бэрхшээлээ танилцуулсан байгаа. Засгийн газрын тогтоол гаргахдаа тухайн байгууллага мэдээллээ оруулах боломжтой талаар ярилцаж байж оруулахгүй бол тухайн яамны хүний нөөц, зохион байгуулалт зэрэг олон асуудлыг харгалзан үзээгүй тогтоол байвал хэрэгжилт дээрээ унана. Иймд төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэг байдаг юм уу, эсвэл ямар нэгэн байдлаар уулзах ёстой гэж бодож байна.

Б.Батболд: Өөр яаман дээр очихоор санаачилга маань уначих байхдаа.

Т.Зууннаст: Ажлын албыг тогтвортой байлгахын тул хуулийн төслөө өргөн барьж батлуулаад, Ерөнхий сайдын багцад ажлын албаны зардлаа суулгадаг болох нь зөв байна. Цахим мэдээллээ ажлын албандаа өгөхөөр хуульчихвал эүгээр байх.

Д.Сүхбаатар: Тэр бол хамгийн зөв арга байна. Тэгэхгүй бол хаягдчих гээд байна.

Б.Батболд: Ийм том санаачилгыг яаманд өгчихөөр нэг мэргэжилтэн хариуцна. Тэр нь ганцхан төсөл хариуцсан мэргэжилтэн суухгүй, давхар өөр юм хариуцна.

Т.Зууннаст: Бид ирэх 7 хоногоос сайдтай уулзана. Тулгамдаж буй асуудлын талаар ярилцах тул Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулиа хуучин байдлаар өргөн барих талаар танилцуулна. Хэрвээ сайд зөвшөөрвөл хэдүүлээ хурлаа зарлаад шууд ажилдаа орох хэрэгтэй. Мэдээллийг ил тод болгох ажлын хэсэгт хүн нэмж оруулаад дахин ажиллая. Хуулийн төслийн үзэл баримтлал 2015 онд батлагдаад, Улсын их хуралд өргөн барьсан. Уянгаа гишүүнээр ахлуулсан бүлэг байгуулагдаад ажиллаж байсан.

Ш.Цолмон: Гуравдугаар асуудлын шийдвэрийн төсөлд дахин сайтар боловсруулах, ажлын хэсэгт танилцуулах, ажлын хэсгийг өргөтгөх гэсэн байдлаар шийдвэрт оруулъя. Ажлын хэсэгт саналаараа орох хүн байна уу? За Сүхбаатар, Оюунтуяа нар нэмж орохоор боллоо. Зууннаст дарга хэвээрээ, нарийн бичиг Ганбат нар нэмэлт бүрэлдэхүүнтэй боллоо. Одоо компанийн төлөөлөл орох хэрэгтэй байна. Ажил хэрэгч санал гарлаа, Та бүхэнд баярлалаа. Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Гуравдугаар асуудлаар гарсан шийдвэр:

“Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэмж “Хариуцлагатай уул уурхайн санаачилга” ТББ-ын зохицуулагч Д.Сүхбаатар, МУУҮА-ийн гүйцэтгэх захирал Д.Энхболд нарыг томилохоор болов. Дэд ажлын хэсэг Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Ажлын хоогийн дараагийн хуралдаанд эргэж танилцуулахээр тогтов.”

Хуралдаан 12,00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ерөнхий сайдын ахлах зөвлөх,
ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн
нарийн бичгийн дарга, ажлын хэсгийн
ахлагч



Б.Энх-Амгалан

Хянасан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
Ажлын албаны зохицуулагч



Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн ажилтан



А.Отгонтунгалаг